**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 29 өдөр Дугаар А/324 Номгон

Номундалай цогцолбор сургуулийн эзэмшил газрыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 5/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмшигч Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Таван Эрдэнийн гудамж-1, 149 тоот хаягт байрлах 1541м2 газар эзэмших эрхийн гэрчилгээг Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхээ шилжүүлж байгаа болон шилжүүлэн авч байгаа байгууллага, аж ахуй нэгжийн үндсэн мэдээллийг хавсралтаар баталсугай.

3.Эзэмшил газрын өөрчлөлтийг цахим системд бүртгэн цахим гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

4.Эзэмшил газраа зориулалтын дагуу зүй зохистой эзэмшиж гэрээнд заасан үүргээ биелүүлж жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигчдэд үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т даалгасугай.

6.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/211 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ДАРГА Э.ЭНХБАТ

620010397

D:\2026\1.Zakhiramj\Zahiramj 01.docx

Аймгийн Засаг даргын 2026 оны 05 дугаар сарын 29 -ний
өдрийн А/324 дүгээр захирамжийн хавсралт

# ГАЗАР ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

| Газар эзэмших эрхээ шилжүүлж буй | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| № | Хуулийн этгээдийн Нэр | Регистрийн дугаар | Нэгж талбарын дугаар | Нэгж талбарын хаяг | Газрын хэмжээ м2 | Хуулийн этгээдийн Нэр | Регистрийн дугаар | Газрын эрхийн төрөл | Нэгж талбарын дугаар | Газрын хэмжээ м2 | Нэгж талбарын хаяг | Газар ашиглалтын зориулалт | Газар эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номун далай цогцолбор сургууль | 9007652 | 6409007856 | Баянхонгор сум, Рашаант 10-р баг, ТаванЭрдэнийн гудамж-1, 149 тоот | 1541 | Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 9007369 | Эзэмших | 6409007856 | 1541 | Баянхонгор сум, Рашаант 10-р баг, ТаванЭрдэнийн гудамж-1, 149 тоот | Боловсролын байгууллага | 7 жил |

----oOo----

ᠪᠠᠶᠢᠭᠠᠯ ᠣᠷᠴᠢᠨ ᠠᠶᠠᠯᠠᠯ
ᠵᠢᠭᠤᠯᠴᠢᠯᠠᠯ ᠤᠨ ᠶᠠᠮᠠᠨ

______ ᠣᠨ ______ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ______ ᠡᠳᠦᠷ

[illegible]

626010663